Эцэст нь дүгнэхэд ХХЕГ-ын даргын бэлтгэл хүчний тусгай салбарыг ангийн зохион байгуулалтанд шилжүүлж бүтэц, удирдлага зохион байгуулалтыг дахин хийж тусгай үүргийн сургалтуудыг нарийн төлөвлөлт зохион байгуулалттайгаар явуулснаар өндөр бэлтгэлтэй болзошгүй аюулыг устгах чадвар бүхий хүнтий нөөц бэлтгэгдэх боломжтой байна.

Олон улсын тусгай албадууд болон түргэн байрлах хүчинд ашиглагдаж байгаа техник хэрэгсэл, өндөр цэцтэй буу, нисдэг тэрэг болон бусад төрлийн зэвсэглэлээр хангах шаардлагатай.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын*
*академийн суралцагч,*
*дэд хурандаа Д.Амархүү*

## ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГАД ИННОВАЦИЙН МЕНЕЖМЕНТИЙГ НЭВТРҮҮЛЭХ НЬ

***Хураангуй.*** *Энэхүү илтгэлээр хил хамгаалах байгууллага түүний бодлого, үйл ажиллагаа /хил хамгаалалт/-нд инновацийн менежментийг хэрхэн нэвтрүүлэх тухай асуудлыг хөндлөө.*

***Тулхүүр*** *үг. Инновag/и, инновацийн менежмент, хил хамгаалах байгууллага, инновациин стратеги*

Өнөө үед дэлхий дахины улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх явдал болсон бөгөөд мэдлэг оюуны үнэ цэнэ үлэмж нэмэгдэн газар, капитал, хөдөлмөрийн нэгэн адил эдийн засгийн нөөц үйлдвэрлэлийн чухал хүчин зүйлийн үүрэг гүйцэтгэх болж, түүнд тулгуурласан инновацийн эдийн засаг бүрэлдэн тогтох үйл явц эрчимтэй өрнөж байна.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнууд шинэ техник, технологийн салбарт өндөр ач холбогдол өгч, төрийн шууд оролцоотойгоор энэ чиглэлийн инкубатор, технопарк, технополис, аж үйлдвэрийн парк, инновацийн төвийг байгуулж байна.

Энэ талаар төр засгаас эхлэлийн тодорхой алхам хийгдэж байгаагийн нэг бол Монгол Улсын инновацийн төвшний үнэлгээг хийх, инновацийн эрх зүйн орчныг бүрдүүлж Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого /1998/, Инновацийн тухайн хууль, Шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер

төлөвлөгөө /2006/, “Монгол Улсад инновацийн тогтолцоо хөгжүүлэх хөтөлбөр[1]” батлагдан гарч хэрэгжиж байна.

Хил хамгаалах байгууллага нь улсын хил хамгаалалтыг зохион байгуулж явуулахад тухайн цаг үеэсээ хамааран шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэн, ашиглаж ирсэн байдаг.

Монгол Улсын засгийн газрын тохируулагч агентлаг болох Хил хамгаалах ерөнхий газар нь төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэгч субьект, шинжлэх ухаан боловсролын байгууллага, тэр дундаа техник технологи, инновацийг үйлдвэрлэгч, бүтээгчидтэй сайтар хамтран ажиллаж, шаардлагатай тохиолдолд тэднийг өөрийн төсвөөс санхүүжүүлж дэмжих, бүтээл хийх орчныг нь бүрдүүлэх зэрэг цогц уялдаатай арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд Шинжлэх ухаан технологийн зөвлөл[2], салбар зөвлөл, улсын хил ба түүх судлал, холбоо мэдээллийн төв, хилийн музей, архив зэрэг судалгаа шинжилгээний байгууллага, 30 гаруй эрдэмтэн, 120 гаруй магистрын бүтээлийн сан байна. Улсын хил хязгаарын аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаа түүнтэй холбогдсон оюуны бүтээлийн үр дүн, практикийн үр ашгийн цогцыг хил хамгаалах байгууллагын байр сууринаас авч үзвэл инновацид хамааралтай гэж үзэх үндэстэй.

Хэдийгээр материаллаг баялаг бүтээдэггүй зөвхөн ашигладаг гэж харагддаг боловч эрдэмтэн, судлаачийн зүгээс хилийн албаны үйл ажиллагаа нь өөрөө улсын хил болон хязгаарын орон зайн эрх зүйт дэглэм, эцсийн бүлэгт улс, нийгэм, хувь хүний аюулгүй байдал хил хязгаарт хандсан бүхий л түвшинг багтаасан бодит бүтээгдэхүүн гэж үзэж, баталсан байдаг. Энэ бүтээгдэхүүнийг үнэ, мөнгөн талаас нь авч үзвэл улсын хилийг зөрчих, аюул учруулах үйлдлийг таслан зогсоосон үнэ цэнэ, улсын хилээр нэвтрэх зорчигч, хил хязгаарт оршин суудаг иргэдэд үзүүлсэн тус дэм, үйлчилгээ, байгаль орчин, соёлын болоод эдийн засгийн баялагийг хилээр хууль бусаар нэвтрүүлэхээс сэргийлэн хамгаалсан үнэ цэнээр хэмжигдэж болно.

Улсын хилийн халдашгүй дархан байдал, улсын хил хязгаарын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь шинжлэх ухааны нийгмийн

[1]Монгол Улсын Засгийн газрын 306 дугаар тогтоол. - УБ., 2007.
[2] Хил хамгаалах ерөнхий газрын даргын тушаал. 2015. 06. 19

хөгжлийн тодорхой үе шатанд тодорхой орон зайд хэрэгжүүлж байгаа баялаг болох нь илэрхий[1] юм.

Аливаа тусгаар тогтносон улсын байгалийн ба нийгмийн баялагыг улсын хил хязгаарт хамгаалж байгаа онцлог, шинж байдлаар мөн чанар нь илэрдэг гэж үзвэл хил хамгаалалт нь улсын хилийн тухай шинэ мэдлэгийг XXI дүгээр зуунд баялаг болгон хувиргаж байгаа нэгэн хэлбэрийн инноваци гэж хэлж болно.

Хил хамгаалах байгууллагын иновацийн удирдлага нь:

> Инновацийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах;
> Инновацийн хөтөлбөрт хөрөнгө оруулах;
> Байгууллага дахь инновацийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;
> Хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжилтэй хүний нөөцийг бэлтгэх, баг бүрдүүлэх;

Энэхүү удирдлагын процесс нь стратегийн менежмент ба маркетинг, төлөвлөлт, зохион байгуулалт, урамшуулалт, мэдээлэл, зохицуулалт, хяналт гэсэн тасралтгүй, харилцан уялдаа бүхий чиг үүрэгтэй. Эдгээр чиг үүрэг нь шинэ зүйлийг судлах, хөгжүүлэх, зохион бүтээх, турших, үйлдвэрлэх, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, инновацийн процесс, түүнийг дэмжих дэд бүтэц, хэрэгжихэд таатай орчныг зөв бүрдүүлэх, харилцан уулдаатай удирдахад чиглэгдэнэ.

Хил хамгаалах байгууллагын инновацийг нэвтрүүлэх стратеги нь түүний хөгжлийн бүх талыг хамрана. Үүнд:

1. Хил хамгаалалтыг зохион байгуулах үеийн инноваци;
2. Технологийн инноваци *(Хил хамгаалалтын чадавхийг бэхжүүлэхийн тулд хөдөлмөрийи бүтээмжийн өсөлт, бүх төрлийн нөөцийн бүрдэлт, хэмнэлт, аюулгүй ажиллагааг хангах, мэдээллийн болон техникийн технологи нэвтрүүлэх);*
3. Зохион байгуулалтын инноваци *(Удирдлага зохион байгуулалтыг сайжруулах прсщесс);*
4. Нийгмийн инноваци *(Байгууллага дахъ нийгмийн орчныг сайжруулах процесс)*

Санал болгож буй инновацийн үйл ажиллагааны чиглэл.

[1] Хууль сахиулахуйн инноваци. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл-1. 70 дахь тал.

> хил хамгаалах байгууллагын хөгжил, стратеги;

> хил хамгаалах тактик, технологи;

Инновацийг нэвтрүүлж хэрэгжүүлэхэд дараах асуудалд анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

1. Инноваци нь хил хамгаалах байгууллагын стратегийн бодлого, төлөвлөлтийн салшгүй хэсэг байх ёстой.
2. Мэдээллийн урсгалыг инновацид нөлөөлдөг, засаглалын инновацийг эрс сайжруулах гол хүчин зүйлийн нэг гэж үздэг тул харилцан ажиллагаатай байгууллагын хооронд мэдээлэл солилцох, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ нээлттэй илтод байх соёлыг нэвтрүүлэх.
3. Инновацийг нэвтрүүлэх, түгээх үйл ажиллагааны үнэт зүйл нь урт хугацаанд болдог тул байгууллага өөрөө инновацийг хүлээн зөвшөөрөх, амжилтийг онцлон тэмдэглэх, сайн туршилтийг түгээх механизмыг хэрэгжүүлдэг байх.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын*
*академийн суралцагч,*
*дэд хурандаа Т.Нурлан*

# ХИЛ ХАМГААЛАЛТЫГ УДИРДАН, ЗОХИОН БАЙГУУЛАХ, ШИЙДВЭР ГАРГАХАД ЭРҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ХАРГАЛЗАХ НЬ

***Хураангуй.*** *Энэхүү илтгэлээр баруун бүсийн БНХАУ-тай хиллэсэн хилийн хэсгийн нөхцөл байдал, түүнд хиисэн дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээ, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлохыг зорьсон болно.*

***Түлхүүр үг.*** *Хил хамгаалах байгууллага, хилийн зөрчил, хилийн нөхцөл байдал, эрүүгийн нөхцөл байдал.*

Манай улсад эрүүгийн нөхцөл байдал хүнд, тэр тусмаа ноцтой гэмт хэргийн эзлэх хувь өндөр, нарийн, далд аргаар бодож төлөвлөсөн, зэвсэглэсэн харгис хэрцгий шинжийг агуулах болсон бөгөөд хил дээр, хил орчимд гарч буй хилийн зөрчилтэй холбоотой хэрэг ч эдгээр шинжийг агуулах болсон төдийгүй террроризмыг нөхцөлдүүлэгч хүчин зүйл болох хар тамхи, сум, галт хэрэгсэлийн наймаа, хууль бус цагаачлал, дүрвэгсэд, хүний наймаа, хил орчмын ард иргэдийн амьдралын доройтол зэрэг нь улсын хилтэй салшгүй холбогдож, улсын хил давуулан оруулах, гаргах, хилээр дамжуулах хэрэг, зөрчил байсаар байна. Мөн хоёр хөрш маань хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, борлуулах, үйлдвэрлэх, зохион байгуулалтай гэмт хэргийн бүлэглэл хүчирхэгжсэн, дэлхийн гэмт хэргийн ертөнцөд нөлөөллөө тогтоосон, далд эдийн засаг, хээл хахууль нийгмийн